# ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Тосонцэнгэл сумын ТТЗ-ийн 2025 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын хураангуй тайлан

**Аудитын код: ХӨА-2026/015/НА-СТА-ТТЗ**

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br><br>Хөвсгөл аймаг<br>2026 он | Дарга, тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар<br>Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn<br>Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр<br>Утас: 99089114 Цахим хаяг: tegshdelgerb@audit.gov.mn<br>Ахлах аудитор: Г.Ичинхорлоо<br>Утас: 88012671 Цахим хаяг: ichnkhorlooga@audit.gov.mn<br>Аудитор: Л.Мөнх-Оргил<br>Утас: 99039344 Цахим хаяг:munkh-orgill@audit.gov.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс:7038 3793, Цахим шуудан:khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2026.03.25 № 01/326

танай ____________-ны № ____________-т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ТОСОНЦЭНГЭЛ СУМЫН ЗАСАГ
ДАРГА Н.САЙНБИЛЭГ ТАНАА

## Хараат бус аудиторын дүгнэлт

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Тосонцэнгэл сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагуудад байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг хасах тодотгол хийсэнтэй холбоотойгоор 212.3 сая төгрөгийн өр төлбөр үүссэн байна.

### Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тосонцэнгэл сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар нягтлан бодох бүртгэлтэй холбоотой 306.7 сая төгрөгийн алдаа, Хоршоо хөгжүүлэх сангийн хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэлтэй 1 аж ахуйн нэгж, 3 иргэнтэй холбоотой 45.7 сая төгрөгийн авлага, харьяа байгууллагуудын өр төлбөр барагдуулж ажиллаагүй нийт 45.7 сая төгрөгийн зөрчил илэрсэн.

**Бусад асуудлын хэсэг**

Тосонцэнгэл сумын Засаг дарга нь нь аймгийн Засаг даргаар 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлуулж, 86.58 хувьтай үнэлгээтэй хэрэгжүүлж ажилласан байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн төвлөрүүлэн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР А.ЭРДЭНЭБААТАР

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/мянган төгрөгөөр/

| № | Дансны нэр, төрөл | Тодруулга | 2024 оны 12-р сарын 31 | 2025 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|---|
| 1 | 1. ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | | 836,065.51 | 997,366.37 |
| 2 | 1.1.1 МӨНГӨН ХӨРӨНГӨ | 3а, 3б | 467,860.11 | 571,112.86 |
| 3 | 1.1.3 АВЛАГА | 5а, 5б, 6а, 6б | 204,363.38 | 118,642.68 |
| 4 | 1.1.5 БАРАА МАТЕРИАЛ | 8а, 8б, 8в | 163,842.02 | 307,610.83 |
| 5 | 1.2 ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | | 2,492,581.87 | 2,477,539.17 |
| 6 | 1.2.1 УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ | 11а, 11б | 15,000 | 31,600 |
| 7 | 1.2.2 ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 12а, 12б, 12в | 2,477,581.87 | 2,445,939.17 |
| 8 | 1.2.2.02 Биет хөрөнгө | | 2,422,020.56 | 2,390,881.86 |
| 9 | 1.2.2.03 Биет бус хөрөнгө | 13 | 55,561.31 | 55,057.31 |
| **10** | **1 НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2** | | **3,328,647.39** | **3,474,905.54** |
| 11 | 2.1 НИЙТ ӨР ТӨЛБӨР | | 77,320.97 | 155,477.2 |
| 12 | 2.1.1 БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | | 77,320.97 | 155,477.2 |
| 13 | 2.1.1.03 Өглөг | | 77,320.97 | 155,477.2 |
| 14 | 2.2 ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | | 3,251,326.42 | 3,319,428.34 |
| 15 | 2.2.1 Засгийн газрын хувь оролцоо | | 3,251,326.42 | 3,319,428.34 |
| 16 | 2.2.1.01 Засгийн газрын оруулсан капитал | | 272,121.27 | 272,121.27 |
| 17 | 2.2.1.02 Өмч /төрийн/ /ТӨҮГ/ | | 249,127.53 | 264,339.13 |
| 18 | 2.2.1.07 Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/ | | 15,211.6 | 0.0 |
| 19 | 2.2.1.08 Хуримтлагдсан үр дүн | | 2,508,053.82 | 2,576,196.57 |
| 20 | 2.2.1.09 Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | | 206,812.2 | 206,771.37 |
| **21** | **2 ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5** | | **3,328,647.39** | **3,474,905.54** |

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/мянган төгрөгөөр/

| № | Дансны нэр, төрөл | Тодруулга | 2024 оны 12-р сарын 31 | 2025 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|---|
| 1 | 1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН | | 2,111,372.54 | 1,976,940.16 |
| 2 | 1.1.1.03 ТАТВАРЫН ОРЛОГО | | 902,297.69 | 911,660.39 |
| 3 | 1.1.1.03.1 Орлогын албан татвар | | 717,388.78 | 681,452.56 |
| 4 | 1.1.1.03.1.01 Хувь хүний орлогын албан татвар | | 717,388.78 | 681,452.56 |
| 5 | 1.1.1.03.3 Хөрөнгийн албан татвар | | 120,274.39 | 159,280.86 |
| 6 | 1.1.1.03.8 Бусад татвар, төлбөр, хураамж | | 64,634.53 | 70,926.97 |
| 7 | 1.1.1.04 ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 1а, 1б | -174,001.02 | 1,065,279.77 |
| 8 | 1.1.1.04.2 Хөрөнгийн орлого | | 1,806.83 | 0.0 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 9 | 1.1.1.04.3 Тусламжийн орлого | | 0.0 | 1,147,512.42 |
| 10 | 1.1.1.05 ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | | 1,383,075.87 | 0.0 |
| 11 | 1.1.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 2а, 2б | 1,855,468.46 | 1,909,940.96 |
| 12 | 1.1.2.01 УРСГАЛ ЗАРДАЛ | | 1,855,468.46 | 1,909,940.96 |
| 13 | 1.1.2.01.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | | 1,701,099.1 | 1,882,800.96 |
| 14 | 1.1.2.01.1.01 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | | 792,600.71 | 951,011.59 |
| 15 | 1.1.2.01.1.02 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | | 98,977.35 | 119,278.67 |
| 16 | 1.1.2.01.1.03 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | | 101,470.57 | 58,261.87 |
| 17 | 1.1.2.01.1.04 Хангамж, бараа материалын зардал | | 88,257.9 | 53,506.42 |
| 18 | 1.1.2.01.1.06 Эд хогшил, урсгал засварын зардал | | 120,978 | 69,080.9 |
| 19 | 1.1.2.01.1.07 Томилолт, зочны зардал | | 10,536.5 | 11,076.11 |
| 20 | 1.1.2.01.1.08 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | | 153,891.67 | 193,944.01 |
| 21 | 1.1.2.01.1.09 Бараа үйлчилгээний бусад зардал | | 334,386.41 | 426,641.38 |
| 22 | 1.1.2.01.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | | 154,369.36 | 27,140 |
| 23 | 1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II) | | 255,904.08 | 66,999.2 |
| 24 | 1.2.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН | | 675.44 | 0.0 |
| 25 | 1.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V) | | -675.44 | 0.0 |
| 26 | 1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII) | | 255,228.64 | 66,999.2 |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/мянган төгрөгөөр/

| № | Дансны нэр, төрөл | 2024 оны 12-р сарын 31 | 2025 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|
| 1 | 1.1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН | 2,432,856.36 | 2,436,598.81 |
| 2 | 1.1.1.1.03 ТАТВАРЫН ОРЛОГО | 902,297.69 | 911,660.39 |
| 3 | 1.1.1.1.03.1 Орлогын албан татвар | 717,388.78 | 681,452.56 |
| 4 | 1.1.1.1.03.3 Хөрөнгийн албан татвар | 120,274.39 | 159,280.86 |
| 5 | 1.1.1.1.03.8 Бусад татвар, төлбөр, хураамж | 64,634.53 | 70,926.97 |
| 6 | 1.1.1.1.03.8.01 Бусад нийтлэг төлбөр, хураамж | 11,142.5 | 17,780.17 |
| 7 | 1.1.1.1.03.8.02 Газрын төлбөр | 7,613.6 | 7,692.75 |
| 8 | 1.1.1.1.03.8.03 Байгалийн нөөц ашигласны төлбөр | 45,878.43 | 45,454.06 |
| 9 | 1.1.1.1.04 ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 147,482.8 | 1,524,938.42 |
| 10 | 1.1.1.1.04.1 Нийтлэг татварын бус орлого | 147,482.8 | 255,819.8 |
| 11 | 1.1.1.1.04.3 Тусламжийн орлого | 0.0 | 1,141,512.42 |
| 12 | 1.1.1.1.04.4 Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг | 0.0 | 127,606.2 |
| 13 | 1.1.1.1.05 ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 1,383,075.87 | 0.0 |

| | | | |
|---|---|---|---|
| 14 | 1.1.1.2 НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 1,905,394.4 | 1,955,383.07 |
| 15 | 1.1.1.2.01 УРСГАЛ ЗАРДАЛ | 1,905,394.4 | 1,955,383.07 |
| 16 | 1.1.1.2.01.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,870,821.4 | 1,928,243.07 |
| 17 | 1.1.1.2.01.1.01 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 974,618.1 | 1,177,070.41 |
| 18 | 1.1.1.2.01.1.02 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 156,675.8 | 119,278.67 |
| 19 | 1.1.1.2.01.1.03 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 136,950.27 | 136,076.93 |
| 20 | 1.1.1.2.01.1.04 Хангамж, бараа материалын зардал | 292,212.61 | 258,869.46 |
| 21 | 1.1.1.2.01.1.05 Нормативт зардал | 2,350 | 0.0 |
| 22 | 1.1.1.2.01.1.06 Эд хогшил, урсгал засварын зардал | 120,282 | 60,683.93 |
| 23 | 1.1.1.2.01.1.07 Томилолт, зочны зардал | 10,536.5 | 11,076.11 |
| 24 | 1.1.1.2.01.1.08 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 107,002.22 | 131,047.51 |
| 25 | 1.1.1.2.01.1.09 Бараа үйлчилгээний бусад зардал | 70,193.9 | 34,140.05 |
| 26 | 1.1.1.2.01.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 34,573 | 27,140 |
| 27 | 1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II) | 527,461.96 | 481,215.74 |
| 28 | 1.1.2.2 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН | 404,148.44 | 337,963 |
| 29 | 1.1.2.2.01 ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 404,148.44 | 337,963 |
| 30 | 1.1.2.2.01.1 Дотоод эх үүсвэрээр | 404,148.44 | 337,963 |
| 31 | 1.1.2 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V) | -404,148.44 | -337,963 |
| 32 | 1.1.3.2 ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ | 30,000 | 40,000 |
| 33 | 1.1.3 САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН | -30,000 | -40,000 |
| 34 | 1.1 НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII) | 93,313.52 | 103,252.74 |
| 35 | 1.2 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 374,546.59 | 467,860.11 |
| 36 | 1 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 467,860.11 | 571,112.86 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/мянган төгрөгөөр/

| № | Дансны нэр, төрөл | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн | Нийт цэвэр хөрөнгө / өмч |
|---|---|---|---|
| 1 | 1.1.1.1.1.1 2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 2,980,886.18 | 2,980,886.18 |
| 2 | 1.1.1.1.1.2 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 1,702.5 | 1,702.5 |
| 3 | 1.1.1.1.1 Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 2,982,588.68 | 2,982,588.68 |
| 4 | 1.1.1.1.2 Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт | -1,702.5 | -1,702.5 |
| 5 | 1.1.1.1.5 Өмчид гарсан өөрчлөлт | 15,211.6 | 15,211.6 |
| 6 | 1.1.1.1.7 Тайлант үеийн үр дүн | 255,228.64 | 255,228.64 |

| | | | |
|---|---|---|---|
| 7 | 1.1.1.1 2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 3,251,326.42 | 3,251,326.42 |
| 8 | 1.1.1 2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл | 3,251,326.42 | 3,251,326.42 |
| 9 | 1.1.2 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 1,143.54 | 1,143.54 |
| 10 | 1.1 Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 3,252,469.97 | 3,252,469.97 |
| 11 | 1.2 Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт | -40.83 | -40.83 |
| 12 | 1.7 Тайлант үеийн үр дүн | 66,999.2 | 66,999.2 |
| 13 | 1 2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл | 3,319,428.34 | 3,319,428.34 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/

| код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| | **НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН** | **2,501,226.10** | **2,334,465.82** | **166,760.28** | **93.33** |
| | НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН | 1,939,438.40 | 1,847,971.12 | 91,467.28 | 95.28 |
| 300001 | Урьд оны үлдэгдэлээс санхүүжих | 561,787.70 | 486,494.70 | 75,293.00 | 86.60 |
| | Татварын бус орлого | 1,939,438.40 | 1,847,971.12 | 91,467.28 | 95.28 |
| | **Нийтлэг татварын бус орлого** | **29,050.00** | **112,132.05** | **(83,082.05)** | **386.00** |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого /үндсэн/ | 23,050.00 | 109,370.38 | (86,320.38) | 474.49 |
| 120010 | Төсөв байгууллагын өөрийн орлого /туслах/ | 6,000.00 | 2,761.68 | 3,238.32 | 46.03 |
| | **Тусламжийн орлого** | **1,780,163.30** | **1,608,232.87** | **171,930.43** | **90.34** |
| 122005 | Төсвөөс санхүүжих | 1,780,163.30 | 1,608,232.87 | 171,930.43 | 90.34 |
| | **Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг** | **130,225.10** | **127,606.20** | **2,618.90** | **97.99** |
| 123002 | Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого | 130,225.10 | 127,606.20 | 2,618.90 | 97.99 |
| | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **2,501,226.10** | **2,215,938.57** | **285,287.53** | **88.59** |
| | **НИЙТ ЗАРЛАГА** | **2,501,226.10** | **2,215,938.57** | **285,287.53** | **88.59** |
| | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,964,310.40** | **1,850,575.57** | **113,734.83** | **94.21** |
| | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,928,496.40** | **1,823,435.57** | **105,060.83** | **94.55** |
| | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **986,731.60** | **951,166.32** | **34,917.23** | **96.40** |
| 210101 | Үндсэн цалин | 498,334.60 | 480,459.21 | 17,875.39 | 96.41 |
| 210102 | Нэмэгдэл | 416,927.20 | 402,262.78 | 14,664.42 | 96.48 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 12,960.00 | 12,311.95 | | |
| 210104 | Урамшуулал | 58,509.80 | 56,132.38 | 2,377.42 | 95.94 |
| | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **123,341.50** | **119,278.67** | **4,062.83** | **96.71** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 83,872.30 | 81,298.27 | 2,574.03 | 96.93 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 9,867.40 | 9,527.23 | 340.17 | 96.55 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 4,933.60 | 4,750.70 | 182.90 | 96.29 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 4,933.60 | 4,713.03 | 220.57 | 95.53 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 19,734.60 | 18,989.43 | 745.17 | 96.22 |
| | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **584,635.50** | **583,249.25** | **1,386.25** | **99.76** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 55,443.30 | 54,057.51 | 1,385.79 | 97.50 |
| 210302 | Түлш, халаалт | 513,392.20 | 513,391.84 | 0.36 | 100.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 15,800.00 | 15,799.90 | 0.10 | 100.00 |
| | **Хангамж, бараа материалын зардал** | **63,966.90** | **42,400.17** | **21,566.73** | **66.28** |
| 210401 | Бичиг хэрэг | 12,666.90 | 6,785.55 | 5,881.35 | 53.57 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 26,700.00 | 18,814.30 | 7,885.70 | 70.47 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 5,500.00 | 3,746.22 | 1,753.78 | 68.11 |
| 210404 | Ном, хэвлэл | 100.00 | 100.00 | - | 100.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 8,448.00 | 4,083.00 | | |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 10,552.00 | 8,871.10 | 1,680.90 | 84.07 |
| | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **65,117.00** | **60,683.93** | **4,433.07** | **93.19** |
| 210604 | Урсгал засвар | 65,117.00 | 60,683.93 | 4,433.07 | 93.19 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | **Томилолт, зочны зардал** | **16,740.00** | **9,780.00** | **6,960.00** | **58.42** |
| 210702 | Дотоод албан томилолт | 16,740.00 | 9,780.00 | 6,960.00 | 58.42 |
| | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **29,983.90** | **23,457.18** | **6,526.72** | **78.23** |
| 210801 | Мэргэжлийн үйлчилгээний төлбөр | 26,958.40 | 21,028.11 | 5,930.29 | 78.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 49.50 | 49.50 | - | 100.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 600.00 | 125.29 | 474.71 | 20.88 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 120.00 | 110.00 | 10.00 | 91.67 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 2,000.00 | 1,888.50 | 111.50 | 94.43 |
| 210807 | Газрын төлбөр | 256.00 | 255.78 | 0.22 | 99.91 |
| | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **57,980.00** | **33,420.05** | **24,559.95** | **57.64** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 46,000.00 | 28,890.35 | 17,109.65 | 62.81 |
| 210902 | Сургалт, дадлага, бэлтгэлийн зардал | 11,980.00 | 4,529.70 | 7,450.30 | 37.81 |
| | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **35,814.00** | **27,140.00** | **8,674.00** | **75.78** |
| | **Бусад урсгал шилжүүлэг** | **35,814.00** | **27,140.00** | **8,674.00** | **75.78** |
| 213204 | Бусад ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 12,600.00 | 12,600.00 | - | 100.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 23,214.00 | 14,540.00 | 8,674.00 | 62.63 |
| | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **435,572.70** | **325,363.00** | **110,209.70** | **74.70** |
| 223001 | Бусад хөрөнгө | 435,572.70 | 325,363.00 | 110,209.70 | 74.70 |
| | **ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ** | **101,343.00** | **40,000.00** | **61,343.00** | **39.47** |
| 230001 | Эргэж төлөгдөх зээл | 101,343.00 | 40,000.00 | 61,343.00 | 39.47 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/

| **Дансны нэр, төрөл** | **Тайлант он** |
|---|---|
| **1.1.1.1 НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН** | **8,909.42** |
| **1.1.1.1.1 ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **8,909.42** |
| **1.1.1.1.1.1 Тусламжийн орлого** | **8,909.42** |
| **1.1.1.1.1.1.1 Хандив тусламж /дотоод/** | **8,909.42** |
| 1.1.1.1.1.1.1.1 Нэмэлт санхүүжилтийн орлого | 8,909.42 |
| 1.1.1.1.1.1.1.1.4 Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 8,727.42 |
| 1.1.1.1.1.1.1.1.5 Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 182.00 |
| | **8,909.42** |
| 1.1.1.2.1 УРСГАЛ ЗАРДАЛ | 8,909.42 |
| 1.1.1.2.1.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 8,909.42 |
| 1.1.1.2.1.1.4 Хангамж, бараа материалын зардал | 7,288.30 |
| 1.1.1.2.1.1.4.2 Тээвэр, шатахуун | 2,518.30 |
| 1.1.1.2.1.1.4.3 Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 150.00 |
| 1.1.1.2.1.1.4.6 Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 4,620.00 |
| 1.1.1.2.1.1.7 Томилолт, зочны зардал | 1,296.11 |
| 1.1.1.2.1.1.7.2 Дотоод албан томилолт | 1,296.11 |
| 1.1.1.2.1.1.9 Бараа үйлчилгээний бусад зардал | 325.0 |
| 1.1.1.2.1.1.9.2 Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 325.00 |

## 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд сумын орон нутгийн ерөнхий орлого болон харьяа 2 төсвийн байгууллага, 2 аж ахуй нэгж, 2 тусгай сан нийт 6 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 1 байгууллагад дүгнэлт гаргаж, 2 сан, 2 аж

ахуй нэгж түүвэрт хамрагдсан байна. Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд "Өөрчлөлтгүй" дүгнэлт өгсөн байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 352.7 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн байна.

Аудитаар нийт 306.7 сая төгрөгийн алдаа[1] илэрснийг аудитын явцад бүрэн залрууллаа. Үүнд:

- Санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайланд 6.0 сая төгрөгийн орлого, 300.7 сая төгрөгийн зардлыг мөр мөрөөр нэгтгээгүй байсныг тус тус залрууллаа.

Аудитаар нийт 45.7 сая төгрөгийн зөрчил[2] илэрч 2 зөвлөмж хүргүүллээ.

***Харьяа байгууллагуудтай холбоотой зөрчил***

Тосонцэнгэл сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар нягтлан бодох бүртгэлтэй холбоотой 133.5 сая төгрөгийн алдаа, 10.2 сая төгрөгийн зөрчил илэрсэн байна. Аудитын явцад 133.5 сая төгрөгийн алдааг залруулж, дээрх зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 1 албан шаардлага, 4 зөвлөмжийг өгсөн байна.

***Төсвийн төвлөрүүлэн захирагчтай холбоотой зөрчил***

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар нийт 306.7 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн байна. Аудитын хугацаанд Санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайланд 6.0 сая төгрөгийн орлого, 300.7 сая төгрөгийн зардлыг мөр мөрөөр нэгтгээгүй алдааг залруулсан.

Тосонцэнгэл сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан болон харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар материаллаг зөрчил илрээгүй бөгөөд тогтоосон материаллаг түвшнээс хэтрээгүй тул зөрчилгүй дүгнэлт өгсөн болно.

### 5.1 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоогоогүй.

### 5.2 Албан шаардлага

Албан шаардлага өгөөгүй.

### 5.3 Зөвлөмж

Цаашид анхаарах асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. **Хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэлтэй холбоотой асуудлын талаар**

1.1. <u>*Аудитын илрүүлэлт:*</u> Тайлант онд Хоршоо хөгжүүлэх сангийн хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэлтэй 1 аж ахуйн нэгж, 3 иргэнтэй холбоотой 45.7 сая төгрөгийн авлага байна. Энэ нь Хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн үлдэгдлийг бүрэн барагдуулаагүй нь Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны 361 дүгээр тушаалаар баталсан *"хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй"* зээл

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

[2] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам"-ын 3.2.1."*орон нутгийн жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх тэргүүлэх чиглэлийг жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ, хоршоо хөгжүүлэх бодлоготой уялдуулан тогтоож, хэрэгжилтийг зохион байгуулах, биелэлтэд нь хяналт тавих*" гэсэн заалттай нийцэхгүй, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж: Хоршоо хөгжүүлэх сангийн хугацаа хэтэрсэн зээлийн авлагыг бүрэн барагдуулж ажиллах

**2. Өр төлбөртэй холбоотой асуудал**

2.1. *Аудитын илрүүлэлт:* Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд үүссэн 155.5 сая төгрөгийн өр төлбөр болж өмнөх оноос 78.1 сая төгрөгөөр нэмэгдсэн ба түүнийг барагдуулахтай холбоотой арга хэмжээг авч ажиллаагүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохимжтой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2.2. Өгсөн зөвлөмж: Үүсэн өр төлбөрийг барагдуулах арга хэмжээ авч, цаашид өр төлбөр үүсэхгүй байхад анхаарч, халаалтын зардлыг нэмэгдсэн үнэ тарифаар санхүүжүүлэх боломжтой эсэхэд дүн шинжилгээ хийж ажиллах

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5 "Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ" гэж заасны дагуу аудитаар илэрсэн зөрчлийг арилгаж ажиллах ажлын төлөвлөгөөг боловсруулан www.fas.audit.mn цахим системд 2026 оны 09 дүгээр сарын 20 -ны өдрийн дотор мэдээлж, баталгаажуулна уу

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 4.АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/сая төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс Залруулсан | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| **ТТЗ-ийн алдаа** | | | | | | | | |
| Тосонцэнгэл сумын ТТЗ | 1 | 306.7 | | | 1 | 306.7 | 1 | 306.7 |
| **Харьяа байгууллагуудын алдаа** | | | | | | | | |
| **Тосонцэнгэл ЗДТГ** | 1 | 4.30 | 1 | 4.30 | | | 1 | 4.30 |
| **Тосон Илч ХХК** | 1 | 129.2 | | | 1 | 129.2 | 1 | 129.2 |
| **Нийт дүн** | 2 | 133.5 | 1 | 4.3 | 1 | 129.2 | 2 | 133.5 |

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

| | | Үүнээс |
|---|---|---|

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| **Төсвийн төвлөрүүлэн захирагчийн зөрчил** | | | | | | | | | | | | |
| Тосонцэнгэл сумын ТТЗ | **2** | **45.7** | | | | | **2** | **45.7** | | | | |
| **Харьяа байгууллагуудын зөрчил** | | | | | | | | | | | | |
| Дүн /Тосонцэнгэл ЗДТГ/ | **2** | 6.4 | **1** | **0.4** | | | **1** | **6.00** | | | | |
| Дүн /Соёлын төв/ | **1** | 0.4 | | | | | **1** | **0.4** | | | | |
| Дүн /Тосон Илч ХХК/ | **3** | **3.45** | | | **1** | **0** | **2** | **3.45** | | | | |
| **НИЙТ ДҮН** | **6** | **10.2** | **1** | **0.4** | **1** | **0** | **4** | **9.8** | | | | |

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | |
| ***Дүн /Тосон Илч ХХК/*** | 1 | 0 | | | *1* | *0* | | |